



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 14 өдөр

Дугаар 4/658

Ховд

Г

Хяналт шалгалт зохион
байгуулах тухай

Г

Төрийн хяналт шалгалтын Монгол Улсын хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Галын аюулгүй байдлын тухай 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өнгөрөгч баасан гарагт буюу 2019 оны 10 дугаар сарын 11-ний шөнө 23:00 цаг орчмын үед Сүхбаатар аймгийн 5 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах "Эрдэнэ Шарга" караокэд гол гарч 1 хүн амь насаа алдаж, 20 гаруй хүн их бага хэмжээгээр түлэгдсэн болон угаартсан байдалтай эмнэлэгт хүргэгдсэнтэй холбогдуулан Жаргалант, Булган суманд үйл ажиллагаа явуулж буй Ресторан, караоке, баар цэнгээний газруудад Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Гамшгаас хамгаалах болон Гал түймрийн улсын хяналтын дүрмийг хэрхэн хэрэгжиж байгаа байдлыг шалгах үзлэгийг 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Хяналт шалгалт зохион байгуулах ажлын хэслгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, хяналт шалгалтын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Хяналт шалгалтыг богино хугацаанд чанартай зохион байгуулж, дүнг 2019 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн дотор Засаг даргын зөвлөлд танилцуулахыг Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа /Б.Алтанбадралт/-д үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

Zax A/658 Ch

02 03259

Аймгийн Засаг даргын
2019 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн
A/658 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

Г.Нэргүй

- Онцгой байдлын газрын орлогч, Урьдчилан сэргийлэх хяналтын тасгийн дарга хошууч

Гишүүдэд :

П.Бямбадорж

- Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах Төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, хошууч

Д.Очирбадам

- Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч хошууч

Б.Оюунбадрах

- Онцгой байдлын газрын Булган сум дахь гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахмад

М.Саруул-эрдэнэ

- Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, хошууч

Нарийн бичгийн

дарга: Г. Ганжаргал

- Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч, дэслэгч

-оОо-

Аймгийн Засаг даргын
2019 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн
A/658 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

УДИРДАМЖ

Жаргалант, Булган суманд үйл ажиллагаа явуулж
буй ресторан, караоке, баар цэнгээний газруудад
хяналт шалгалтыг явуулах тухай

Нэг.Хяналт шалгалтын зорилго

Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж,
гамшгаас хамгаалах болон гол түймрийн улсын хяналтын дүрэм, галын аюулгүй
байдлын стандарт, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах
төлөвлөгөөт хяналт шалгалтыг Жаргалант, Булган суманд үйл ажиллагаа явуулж
буй ресторан, караоке, баар цэнгээний газруудад зохион байгуулж, болзошгүй
эрсдэлийг бууруулахад оршино.

Хоёр.Ерөнхий зүйл

2.1.Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Зөрчлийн
тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Төрийн хяналт шалгалтын тухай,
Гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, гол түймрийн
улсын хяналтын дүрэм, бусад галын аюулгүй байдлын норм нормативын баримт
бичиг уг шалгалтыг явуулах эрх зүйн үндэс болно.

2.2.Хяналт шалгалтанд оролцох бүрэлдэхүүн дээрх хууль тогтоомж, галын
уюулгүй байдлын норм, нормативын баримт бичиг болон энэхүү удирдажийг
баримтлан ажиллана.

2.3.Жаргалант, Булган сумдын хэмжээнд үйл ажиллагаа буй ресторан,
караоке, баар цэнгээний газруудад хяналт шалгалтыг зохион байгуулна.

2.4.Гамшгаас хамгаалах болон Гол түймрийн улсын хяналтын байцаагчид
нар хууль тогтоомж, дүрмээр олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт
шалгалтыг гүйцэтгэж, илэрсэн зөрчил арилгуулах, гүйцэтгэлийн хяналт

шалгалтаар зөрчил арилгаагүй тохиолдолд Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл ноогдуулна.

2.5.Хяналт шалгалтыг “Ресторан, караоке, баар цэнгээний газруудад гамшигаас хамгаалах болон галын аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас” загварын дагуу шалгана.

2.6.Хяналт шалгалт хийсэн тухай мэдээллийнг улсын хяналтын байцаагчийн өдөр тутмын ажлын мэдээний цахим бүртгэлийн программын мэдээллийн санд нэг бүрчлэн оруулсан байна.

Гурав.Хяналт шалгалт явуулах хугацаа, зардал

3.1. Хяналт шалгалтын ажлын хэсгийг төв, орон нутгийн Гамшигаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий албан тушаалтан зохион байгуулна.

3.2.Томоохон Ресторан, караоке, баар цэнгээний газруудад хяналт шалгалтыг хийхдээ 3-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг тушаалаар томилон ажиллуулна.

3.3. Хяналт шалгалтыг 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс 2019 оны 10 дугаар сарын 18-ний өдрийн хооронд зохион явуулна.

3.4. Хяналт шалгалтын дүн, мэдээг 2019 оны 10 дугаар сарын 10-ний дотор Аймгийн Засаг даргын зөвлөлд зөрчлийг фото зургаар баримтжуулан илтгэх хуудасны хамт танилцуулна.

Дөрөв.Хяналт шалгалтын үр дүн, авах арга хэмжээ

4.1.Хяналт шалгалтын талаарх мэдээлэл, зөвлөмж, зааварчилгыг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагын цахим хуудсанд байршуулж олон нийтэд хүргэнэ.

4.2.Хяналт шалгалтын дүнг Аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулж холбогдох яам, агентлаг, газрын дарга нарт гал түймрийн улсын хяналтын байцаагчийн танилцуулга, мэдэгдэл, заавал биелүүлэх албан шаардлага хүргүүлэн биелэлтийг ханггуулна.

-оОо-